

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дэлгэр сумын Гуулин тосгоны Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/042/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: <a href="mailto:gunjidmaag@audit.gov.mn">gunjidmaag@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Дэлгэрчимэг Утас: 99175677 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a> Цэгц богд төв аудит ХХК-ийн Ахлах аудитор: Р.Цанжидмаа Утас: 99029885 Цахим хаяг: <a href="mailto:tsania.0215@gmail.com">tsania.0215@gmail.com</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2026/042/НА-СТА-ТШЗ



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091  
Утас: (976) 7048-4030,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026.02.24

№

85

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ДЭЛГЭР СУМЫН ГУУЛИН ТОСГОНЫ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
Д.ЦЭЭНОРОВ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлгэр сумын Гуулин тосгоны Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй болно. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын цахим системд илгээсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэл, нэхэмжилсэн дүнгээс чанарын болон төлбөрийн хяналтаар 4,436.5 мянган төгрөг хасагдсан.
- Батлагдсан төсөвт тусгасан 30,400.0 мянган төгрөгийн шатахуун худалдан авахдаа тендер зохион байгуулаагүй.
- Хандив тусламж болон бусад эх үүсвэрээр бэлтгэсэн 62 нэр төрлийн бараа материал, үндсэн хөрөнгийг орлого авахдаа байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжгүйгээр данс бүртгэлд тусгасан.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, 16.5.5, 24 дүгээр зүйлийн 24.4, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.3-т "хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэл", Говь-Алтай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн ажиллах журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тус Эрүүл мэндийн төв тайлант онд 282 иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн ба өмнөх оны авлага барагдуулж 77,602.9 мянган төгрөгийг санхүүжилт олгосон байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 8,500.0 мянган төгрөгийн, хандив тусламжаар ирсэн 3,499.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авсан байна.

#### **Аудитын гол асуудал**

Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр 465,124.5 мянган төгрөг нэхэмжилснээс 428,104.5 мянган төгрөг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжигдэж, 4,436.5 мянган төгрөг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтаар хасагдаж 32,583.5 мянган төгрөг авлагаар тайлагнасан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 3 зорилтын хүрээнд 47 арга хэмжээ хэрэгжүүлэхээр сумын Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулан гүйцэтгэлээр 85.0 хувиар дүгнүүлжээ.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргатай байгуулсан эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулан ажиллаж, гэрээний биелэлт 65.8 хувь байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.ҮНЖИДМАА

**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан СТ-1 (төгрөгөөр)**

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	46,353,957.35	28,354,058.97
Банкинд байгаа бэлэн мөнгө/ төгрөгөөр/	46,353,957.35	28,354,058.97
Төрийн сангийн харилцах дансанд байгаа мөнгө	46,353,957.35	28,354,058.97
АВЛАГА	77,602,961.65	32,884,327.01
Төлбөртэй үйлчилгээний авлага	77,602,961.65	32,583,527.01
Байгууллагаас авах авлага		300,800.00
БАРАА МАТЕРИАЛ	40,831,343.62	38,562,262.43
Түүхий эд материал	30,142,785.72	25,708,473.93
Эм боох материал	30,142,785.72	25,708,473.93
Хангамжийн материал	10,688,557.90	12,853,788.50
Аж ахуйн материал	5,051,000.00	5,051,000.00
Түлш, шатах тослох материал	3,124,907.90	3,125,600.50
Хүнсний материал	1,475,650.00	3,557,188.00
Бусад хангамжийн материал	1,037,000.00	1,120,000.00
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	164,788,262.62	99,800,648.41
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	508,762,889.73	519,312,013.72
Биет хөрөнгө	503,860,889.73	514,410,013.72
Барилга, байгууламж, орон сууц	293,200,346.39	338,813,546.39
Хуримтлагдсан элэгдэл	(51,931,088.23)	(61,097,896.75)
Авто-тээврийн хэрэгсэл	209,635,800.47	209,635,800.47
Хуримтлагдсан элэгдэл	(29,736,434.00)	(41,729,725.04)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	118,988,042.06	130,987,142.06
Хуримтлагдсан элэгдэл	(46,575,269.65)	(69,786,160.86)
Тавилга, аж ахуйн эд хогшил	13,378,178.00	13,378,178.00
Хуримтлагдсан элэгдэл	(6,682,018.53)	(8,874,203.73)
Бусад үндсэн хөрөнгө	5,000,000.00	5,000,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(1,416,666.78)	(1,916,666.82)
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	4,902,000.00	4,902,000.00
Программ	600,000.00	600,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(600,000.00)	(600,000.00)
Бусад биет бус хөрөнгө	4,902,000.00	4,902,000.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	508,762,889.73	519,312,013.72
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	673,551,152.35	619,112,662.13
Ажилчидтай холбогдсон өглөг		3,225,296.14
Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,367,096.20	5,215,096.20

Байгууллагад төлөх өглөг	940,531.51	
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	3,307,627.71	8,440,392.34
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	3,307,627.71	8,440,392.34
Засгийн газрын хувь оролцоо	334,431,867.89	334,431,867.89
Дахин үнэлгээний нэмэгдэл	163,973,504.05	163,973,504.05
Хуримтлагдсан үр дүн	171,838,152.70	112,266,897.85
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	670,243,524.64	610,672,269.79
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	673,551,152.35	619,112,662.13

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан СТ-2** (төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ	ТАЙЛАНТ ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	510,625,464.28	491,888,073.10
Орон нутгийн төсвөөс	18,300,000.00	31,200,000.00
Эрүүл мэндийн даатгалын сангаас	492,325,464.28	460,688,073.10
Бараа, үйлчилгээний орлого	225,841,153.31	8,712,219.53
Хандивын тусламжийн орлого Үндсэн хөрөнгө	211,942,512.87	3,499,100.00
Хандивын тусламжийн орлого Бараа материал	5,768,730.44	5,213,119.53
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	8,129,910.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	736,466,617.59	500,600,292.63
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
<u>АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ</u>	333,356,727.55	415,379,676.75
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	301,896,862.81	372,310,488.30
Үндсэн цалин	210,190,155.12	240,422,745.68
Нэмэгдэл	71,554,107.69	90,509,209.84
Унаа хоолны хөнгөлөлт	2,319,000.00	16,690,000.00
Урамшуулал	17,833,600.00	24,688,532.78
Нийгмийн хамгааллын шимтгэл	31,459,864.74	43,069,188.45
Тэтгэврийн даатгал	22,376,120.67	28,956,675.60
Тэтгэмжийн даатгал	2,469,747.23	3,674,276.93
ҮОМШӨ-ний даатгал	1,658,549.33	2,434,398.47
Ажилгүйдлийн даатгал	903,231.66	1,812,818.72
Эрүүл мэндийн даатгал	4,052,215.85	6,191,018.73
<u>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ</u>	134,187,705.47	141,440,542.50
Тогтмол зардал	15,190,115.33	17,670,346.77
Гэрэл цахилгааны зардал	1,620,019.49	2,905,346.77
Түлш, халаалтын зардал	13,430,095.84	14,765,000.00
Цэвэр, бохир усны зардал	140,000.00	-
Нормативт зардал	41,905,617.51	44,832,483.32
Эм	35,298,947.51	36,569,116.32
Хоол	6,606,670.00	6,303,367.00
Нормын хувцас зөөлөн эдлэл	-	1,960,000.00
Хангамж бараа үйлчилгээний зардал	36,600,220.62	19,313,211.40

Бичиг хэргийн материал	828,600.00	850,400.00
Тээвэр, шатахууны зардал	10,475,800.40	14,645,911.40
Шуудан холбооны зардал	1,034,000.00	1,501,700.00
Хог хаягдал зайлуулах зардал	9,848,450.00	-
Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйл	14,413,370.22	2,315,200.00
Эд хогшил урсгал засварын зардал	1,817,500.00	4,457,225.00
Урсгал засвар	1,817,500.00	4,457,225.00
Томилолт зочны зардал	452,000.00	1,460,000.00
Дотоод томилолтын зардал	452,000.00	1,460,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	349,850.00	5,644,100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	349,850.00	4,426,500.00
Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох	-	777,600.00
Маягт хэвлүүлэх зардал	-	440,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	37,872,402.01	48,063,176.01
Бусад зардал	3,729,200.00	1,000,000.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	34,143,202.01	47,063,176.01
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	439,980.87	3,351,328.23
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	439,980.87	2,986,328.23
Төвлөрүүлэх шилжүүлэг	439,980.87	2,986,328.23
Бусад урсгал шилжүүлэг	-	365,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	365,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	467,984,413.89	560,171,547.48
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	268,482,203.70	(59,571,254.85)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	268,482,203.70	(59,571,254.85)

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-3

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
Татаас, санхүүжилтийн орлого	434,231,347.63	536,907,507.74
Орон нутгийн төсвөөс	18,300,000.00	31,200,000.00
Эрүүл мэндийн даатгалын сангаас	415,931,347.63	505,707,507.74
Бараа, үйлчилгээний орлого	8,129,910.00	-
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	8,129,910.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	442,361,257.63	536,907,507.74
Ажиллагчидтай холбогдсон зардал	333,356,727.55	412,154,380.61
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	301,749,144.44	369,085,192.16
Үндсэн цалин	209,778,436.75	237,197,449.54
Нэмэгдлүүд	71,554,107.69	90,509,209.84
Унаа хоолны хөнгөлөлт	2,583,000.00	16,690,000.00
Урамшуулал	17,833,600.00	24,688,532.78
Нийгмийн хамгааллын шимтгэл	31,607,583.11	43,069,188.45
Тэтгэврийн даатгал	22,376,120.67	28,956,675.60
Тэтгэмжийн даатгал	2,469,747.23	3,674,276.93
ҮОМШӨ-ний даатгал	1,698,267.70	2,434,398.47

Дэлгэр сумын Гуулин тосгоны Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Ажилгүйдлийн даатгал	1,011,231.66	1,812,818.72
Эрүүл мэндийн даатгал	4,052,215.85	6,191,018.73
Бараа ,үйлчилгээний урсгал зардал	89,002,883.84	85,288,497.28
Тогтмол зардал	13,860,019.13	14,905,346.77
Гэрэл цахилгааны зардал	1,620,019.49	2,905,346.77
Түлш, халаалтын зардал	12,099,999.64	12,000,000.00
Цэвэр, бохир усны зардал	140,000.00	-
Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал	47,013,492.11	38,270,441.51
Эм	39,546,182.11	27,862,236.51
Хоол	4,900,210.00	8,448,205.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,567,100.00	1,960,000.00
Хангамж бараа үйлчилгээний зардал	16,314,822.60	19,551,384.00
Бичиг хэрэг	843,600.00	850400.00
Тээвэр, шатахуун	12,643,872.60	14646584.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,034,000.00	1501700.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,793,350.00	2552700.00
Эд хогшил, урсгал засварын зардал	9,392,000.00	4,457,225.00
Багаж, техник, хэрэгсэл	2,142,000.00	-
Урсгал засвар	7,250,000.00	4,457,225.00
Томилолт, зочны зардал	452,000.00	1,460,000.00
Дотоод албан томилолт	452,000.00	1,460,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	356,850.00	5,644,100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	356,850.00	4,426,500.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	777,600.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	440,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	1,613,700.00	1,000,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	1,613,700.00	1,000,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	439,980.87	3,351,328.23
Бусад урсгал шилжүүлэг	-	365,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	365,000.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	439,980.87	2,986,328.23
Төвлөрүүлэх шилжүүлэг	439,980.87	2,986,328.23
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	422,799,592.26	500,794,206.12
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	19,561,665.37	36,113,301.62
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	12,744,605.00	54,113,200.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН(V)	12,744,605.00	54,113,200.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV) - (V)	(12,744,605.00)	(54,113,200.00)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX) = (VII) + (VIII)	6,817,060.37	(17,999,898.38)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	39,536,896.98	46,353,957.35
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	46,353,957.35	28,354,058.97

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан СТА - 4**  
(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	334,431,867.89	163,973,504.05	(96,644,051.00)	401,761,320.94
Залруулсан үлдэгдэл	334,431,867.89	163,973,504.05	(96,644,051.00)	401,761,320.94
Тайлант үеийн үр дүн	-	-	268,482,203.70	268,482,203.70
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	334,431,867.89	163,973,504.05	171,838,152.70	670,243,524.64
Залруулсан үлдэгдэл	334,431,867.89	163,973,504.05	171,838,152.70	670,243,524.64
Тайлант үеийн үр дүн	-	-	(59,571,254.85)	(59,571,254.85)
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	334,431,867.89	163,973,504.05	112,266,897.85	610,672,269.79

**2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан СТ-4-1**  
(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
Татаас, санхүүжилтийн орлого	541,040,600.00	505,707,507.74	35,333,092.26	93.5
Эрүүл мэндийн даатгалын сангаас	541,040,600.0	505,707,507.74	35,333,092.26	93.5
Бараа, үйлчилгээний орлого	46,353,900.00	-	46,353,900.00	-
Урьд оны үлдэгдлээс	46,353,900.00		46,353,900.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	587,394,500.00	505,707,507.74	81,686,992.26	86.1
Ажиллагчидтай холбогдсон зардал	416,212,900.00	412,154,380.61	4,058,519.39	99.0
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	370,199,600.00	369,085,192.16	1,114,407.84	99.7
Үндсэн цалин	254,899,000.0	237,197,449.54	17,701,550.46	93.1
Нэмэгдэл	70,804,400.0	90,509,209.84	(19,704,809.84)	127.8
Унаа хоолны хөнгөлөлт	19,133,700.0	16,690,000.00	2,443,700.00	87.2
Урамшуулал	25,362,500.0	24,688,532.78	673,967.22	97.3
Нийгмийн хамгааллын шимтгэл	46,013,300.00	43,069,188.45	2,944,111.55	93.6
Тэтгэврийн даатгал	30,599,400.0	28,956,675.60	1,642,724.40	94.6
Тэтгэмжийн даатгал	3,728,500.0	3,674,276.93	54,223.07	98.5
Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал	2,364,200.0	2,434,398.47	(70,198.47)	103.0
Ажилгүйдлийн даатгал	1,864,200.0	1,812,818.72	51,381.28	97.2

Дэлгэр сумын Гуулин тосгоны Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Эрүүл мэндийн даатгал	7,457,000.0	6,191,018.73	1,265,981.27	83.0
Бараа ,үйлчилгээний урсгал зардал	168,831,600.00	111,188,025.51	57,643,574.49	65.9
Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал	63,986,400.00	38,270,441.51	25,715,958.49	59.8
Эм, боох материал	48,361,400.0	27,862,236.51	20,499,163.49	57.6
Хоол, хүнс	13,000,000.0	8,448,205.00	4,551,795.00	65.0
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	2,625,000.0	1,960,000.00	665,000.00	74.7
Бусад бараа үйлчилгээний зардал	40,218,700.00	19,551,384.00	20,667,316.00	48.6
Бичиг хэргийн материал	2,227,600.0	850,400.00	1,377,200.00	38.2
Тээвэр, шатахууны зардал	30,400,000.0	14,646,584.00	15,753,416.00	48.2
Шуудан холбооны зардал	2,160,000.0	1,501,700.00	658,300.00	69.5
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	431,100.0	-	431,100.00	-
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.0	2,552,700.00	2,447,300.00	51.1
Жижиг эд хогшил худалдан авах зардал	53,931,500.00	45,262,100.00	8,669,400.00	83.9
Багаж, техник, хэрэгсэл	14,000,000.0	8,500,000.00	5,500,000.00	60.7
Урсгал засварын зардал	39,931,500.0	36,762,100.00	3,169,400.00	92.1
Томилолт зочны зардал	2,700,000.0	1,460,000.0	1,240,000.00	54.1
Дотоод томилолтын зардал	2,700,000.00	1,460,000.00	1,240,000.00	54.1
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	6,995,000.00	5,644,100.00	1,350,900.00	80.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,720,000.0	4,426,500.00	293,500.00	93.8
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,300,000.0	777,600.00	522,400.00	59.8
Маягт хэвлүүлэх зардал	975,000.00	440,000.00	535,000.00	45.1
Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
Бусад зардал	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
<u>Урсгал шилжүүлэг</u>	2,350,000.00	365,000.00	1,985,000.00	15.5
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	2,350,000.00	365,000.00	1,985,000.00	15.5
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>587,394,500.00</b>	<b>523,707,406.12</b>	<b>63,687,093.88</b>	<b>89.2</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	46,353,957.35	46,353,957.35	-	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	28,354,058.97	-	-

**2.5.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Орон нутгийн төсвийн/ СТ-4-2 / (төгрөгөөр)**

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татаас, санхүүжилтийн орлого	31,200,000.00	28,213,671.77	2,986,328.23	90.4
Орон нутгийн төсвөөс	31,200,000.00	28,213,671.77	2,986,328.23	90.4
Тогтмол зардал	31,200,000.00	28,213,671.77	2,986,328.23	90.4
Гэрэл цахилгааны зардал	4,000,000.0	2,905,346.77	1,094,653.23	72.6
Түлш, халаалтын зардал	12,000,000.0	12,000,000.00	-	100.0
Цэвэр бохир ус	200,000.0	-	200,000.00	-
Урсгал зардал	15,000,000.0	13,308,325.00	1,691,675.00	88.7
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>31,200,000.00</b>	<b>28,213,671.77</b>	<b>2,986,328.23</b>	<b>90.4</b>

**ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

**3.1 Аудитаар 598,991.2 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.**

Залруулсан алдаа:

**Бүртгэл тайлантай холбоотой:** Цалингаас суутгасан 3,225.3 мянган төгрөгийн хувь хүний орлогны албан татварын өглөгийг төлөөгүй, өглөгөөр тайлагнаагүй, барилгад хийсэн их засварын 26,485.3 мянган төгрөгийг сайжруулалтаар бүртгээгүй зардал болгосон зэрэг алдааг тус тус залруулан тайлагнасан.

**Мэдээллийг орхигдуулсантай холбоотой:** Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 569,280.6 мянган төгрөгийн 30 мэдээллийг мэдээлээгүйг нөхөн байршууллаа.

Аудитаар залруулагдаагүй 34,836.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар илэрсэн 34,836.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 зөвлөмж өгсөн.

**3.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**Нэг. Хандив тусламжаар ирсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Хандив тусламж болон бусад эх үүсвэрээр бэлтгэсэн 62 нэр төрлийн бараа материал, үндсэн хөрөнгийг орлого авахдаа байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжгүйгээр данс бүртгэлд тусгасан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.3-т "хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэл", Говь-Алтай аймгийн ИТХ-ын 2025 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

хамгаалах Байнгын зөвлөлийн ажиллах журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1-т "Зөвлөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу хуулийн этгээдийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, акталж данснаас хасах зэрэг эд хөрөнгийн зохицуулалт, орон нутгийн өмчийн үр ашгийг дээшлүүлэх асуудлыг судалж, санал, зөвлөмж, дүгнэлт гаргана" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах, дахин үнэлгээ хийх зэрэг эд хөрөнгийн зохицуулалт, хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх асуудлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлөөр хэлэлцүүлж дүгнэлт, зөвлөмж гаргуулж ажиллах.

#### **Хоёр. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилттэй холбоотой**

**Илрүүлэлт:** Эрүүл мэндийн даатгалын цахим системд илгээсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэл, нэхэмжилсэн дүнгээс чанарын болон төлбөрийн хяналтаар 4,436.5 мянган төгрөг хасагдсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага дараах эрх, үүрэгтэй: 13.1.1.даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх", 13.1.6-д "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үйлчилгээний орлогыг бүрэн төвлөрүүлэн, байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлж, дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах.

#### **Гурав. Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой.**

**Илрүүлэлт:** Батлагдсан төсөвт тусгасан 30,400.0 мянган төгрөгийн шатахуун худалдан авахдаа тендер зохион байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Босго үнээс давсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хуулийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулж байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дэлгэр сумын Гуулин тосгоны Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл**

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:			Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2 Шилэн дансны цахим системд 569,280.6 мянган төгрөгийн 30 мэдээллийг ил тод байршуулаагүй.	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
		1	569,280.6	1	569,280.6	-	-	1	569,280.6		-	-	-
Дэлгэр сумын Гуулин тосгоны эрүүл мэндийн төв	Цалингаас суутгасан 3,225.3 мянган төгрөгийн ХХОАТыг төлөөгүй, өглөгөөр тайлагнаагүй	1	3,225.3	-	-	1	3,225.3	1	3,225.3		-	-	-
	Барилгад хийсэн их засварын 26,485.3 мянган төгрөгийг сайжруулалтаар бүртгээгүй зардал болгосон	1	26,485.3			1	26,485.3	1	26,485.3				
<b>Дүн</b>		<b>3</b>	<b>598,991.2</b>	<b>1</b>	<b>569,280.6</b>	<b>2</b>	<b>29,710.6</b>	<b>3</b>	<b>598,991.2</b>		<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>



Дэлгэр сумын Гуулин тосгоны Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

4.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан санхүүгийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10
	Батлагдсан төсөвт тусгасан 30,400.0 мянган төгрөгийн шатахуун худалдан авахдаа тендер зохион байгуулаагүй.	1	30,400.0	-	-	-	-	1	30,400.0
	Хандив тусламж болон бусад эх үүсвэрээр бэлтгэсэн 62 нэр төрлийн бараа материал, үндсэн хөрөнгийг орлого авахдаа байгууллагын Өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжгүйгээр данс бүртгэлд тусгасан.	1	-	-	-	-	-	1	-
	Эрүүл мэндийн даатгалын цахим системд илгээсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэл, нэхэмжилсэн дүнгээс чанарын болон төлбөрийн хяналтаар 4,436.5 мянган төгрөг хасагдсан байна.	1	4,436.5	-	-	-	-	1	4,436.5
	Нийт дүн	3	34,836.5	--	-	-	-	3	34,836.5

Бүтэц: Өмч-Материал-Төсөв  
Хүндэтгэл: Аудит  
Төв, АЗ

Дэлгэр сумын Гуулин тосгоны Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Санал дүгнэлт гаргасан	Түвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Өрчлөлтий	Хязгарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
А	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТШЗ	1	1				1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>			

Хураангуйтай  
Төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан  
2025.08.28